

## 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

### ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991-2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- **Баруун** (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- **Төв** (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул)
- **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- **Говь** (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон "Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн "Цаг Агаар, Орчны Тоон Загварчлал Судалгааны Хэлтэс"–ээс тодруулах боломжтой.

### ӨВЛИЙН УЛИРАЛД ОРДОГ ЦАСНЫ ДУНДАЖ ХЭМЖЭЭ


Зураг 1а) 1981–2020 оны 11 дүгээр сард цас орсон өдрийн тоо, 1б) хүйтэн улирлын (X–II сар) хоногийн дундаж цасны зузааныг харуулав. Зураг 1а–аас харахад Их нууруудын хотгор, Дархадын хотгор, Орхон, Сэлэнгэ, Туул голын сав газар болон Дорнод, Монголын тал нутгаар сард дунджаар 5–7 өдөр, бусад нутгаар 1–5 өдөр цас ордог байна. Эндээс уул зүйн нөлөөгөөр уулынхаа ард талд бага хэмжээний бага даралтын орон гүнзгийрч хотгор газрууд болон гол нуурын хөндийгөөр цас орох тохиолдол харьцангуй их байдаг нь харагдаж байна. Харин зураг 1б–ээс харахад манай оронд X сараас эхлэн цасан бүрхүүл үүсч, 11 дүгээр сарын сүүл гэхэд цасны зузаан 3,5–4,5 см хүрч нэмэгддэг байна.



**Зураг 1. 1981–2020 оны 11–р сард шинэ орсон цастай өдрийн тоо**


### УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Арваннэгдүгээр сарын агаарын температурын ОЖД нь Алтай, Хангай, Хэнтийн уулархаг нутгаар -12...-18°C, Хөвсгөлийн уулархаг нутгаар -18...-22°C, Алтайн өвөр говь болон говийн бүс нутаг, Дорнодын тал газраар -2...-8°C, бусад нутгаар -8...-12°C хүйтэн байдаг байна (**Зураг 2**).



**Зураг 1. 11-р сарын агаарын температурын ОЖД, [°C].**


Арваннэгдүгээр сарын агаарын дундаж температур 1979, 1981, 1984–1987, 1989, 1993, 1996, 2000, 2002–2003, 2009, 2011–2012, 2015–2016 онуудад нийт нутгаар ОЖД-аас 1–5°C-аар хүйтэн байсан бол 1980, 1983, 1988, 1994–1995, 1998–1999, 2001, 2005–2008, 2010, 2013–2014, 2020–2021 онуудад ОЖД-аас 1–3°C-аар дулаан байсан байна (**Зураг 3**).



**Зураг 2. 11-р сарын агаарын температурын олон жилийн явц**


**[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]**

Сарын нийлбэр хур тунадас Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 4–8 мм, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–4 мм ордог (**Зураг 4**).



**Зураг 3. 11-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм].**

Зарим жил ОЖД-аас хэд дахин их болон бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 1979, 1987, 1990, 1992, 1996, 2000, 2003, 2009–2012, 2015–2016 онуудад зарим нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон байна. Харин 1985, 1988–1989, 1995, 1997, 1999, 2004–2008, 2014, 2018, 2021 онууд харьцангуй бага хур тунадастай байсан байна (**Зураг 5**).



**Зураг 4. 11-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц**

[Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

**Баруун аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур болон хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим (**Зураг 6**), (**Зураг 7**) байна.

Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 8**-д харуулав. Нэг, хоёр, гуравдугаар арав хоногуудын эхэн үе болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр агаарын температур ОЖД-аас 4–6°C-аар сэрүүснэ.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, дунд үеүдээр ихэнх нутгаар хур тунадас орно. Энэ үеэр салхи зарим газраар 11–13 м/с, зарим үед түр зуур 13–15 м/с хүрч ширүүсч болзошгүй.

**Төвийн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур Булганы ихэнх, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгуудын нутгаар ОЖД-аас дулаан ба бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**), хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим (**Зураг 7**) байна.

Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 9**-д харуулав. Нэг ба гуравдугаар арав хоногуудын эхэн, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр агаарын температур ОЖД-аас 4–6°C-аар сэрүүснэ.

Нэг болон хоёрдугаар арав хоногийн эхэн, дунд үеүдээр ихэнх нутгаар хур тунадас орно. Энэ үеэр салхи зарим газраар 10–12 м/с, зарим үед түр зуур 12–14 м/с хүрч ширүүсч болзошгүй.

**Зүүн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-аас дулаан (**Зураг 6**), хур тунадас ихэнх нутгаар (Хэнтийн баруун хэсгээс бусад) ОЖД-аас бага байна (**Зураг 7**).


Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 10**-д харуулав. Гурван арав хоногийн эхэн, нэг болон хоёрдугаар арав хоногуудын сүүлчээр агаарын температур ОЖД-аас 3–5°C-аар сэрүүснэ.

Нэгдүгээр арав хоногийн эхэн, дунд, хоёрдугаар арав хоногийн дунд–сүүлч үеэр ихэнх нутгаар хур тунадас орно. Энэ үеэр салхи ширүүсч, зарим газраар 12–14 м/с, зарим үед түр зуур 14–16 м/с хүрч ширүүсч болзошгүй.

**Говийн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар ОЖД-ийн орчим, Дундговь, Дорноговийн зүүн хойд хэсэг болон Говьсүмбэрийн нутгаар дунджаас дулаан (**Зураг 6**), хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим (**Зураг 7**) байна.


Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 11**-т харуулав. Гурван арав хоногийн эхэн, нэг болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр агаарын температур ОЖД-аас 3–5°C-аар сэрүүснэ.

Нэг, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар хур тунадас орох төлөвтэй. Энэ үеэр салхи ширүүсч 13–15 м/с хүрэх буюу зарим үед 15–17 м/с хүрч ширүүсч болзошгүй.




**Зураг 5. 2022 оны 11–р сарын агаарын дундаж температурын урьдчилсан мэдээ, С°**

**[Н – агаарын температур ОЖД-ийн орчим, Д – агаарын температур ОЖД-аас дулаан]**




**Зураг 6. 2022 оны 11-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан мэдээ, мм**

**[Н – хур тунадас ОЖД-ийн орчим, Б – хур тунадас ОЖД-аас бага]**




**Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2022 оны 11-р сарын температур, хур тунадасны явц**

**[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, ногоон – хур тунадасны хэмжээ]**




**Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2022 оны 11–р сарын температур, хур тунадасны явц**

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **ногоон** – хур тунадасны хэмжээ]



**Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2022 оны 11–р сарын температур, хур тунадасны явц**

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **ногоон** – хур тунадасны хэмжээ]



**Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2022 оны 11–р сарын температур, хур тунадасны явц**

**[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, ногоон – хур тунадасны хэмжээ]**

### **ЗӨВЛӨМЖ**

Арваннэгдүгээр сард нутгийн зүүн хойд хэсгээр ОЖД-аас дулаан, хур тунадас бага байх төлөвтэй байна.

Сарын эхээр ихэнх нутгаар хур тунадас орох ба говь, тал хээрийн бүс нутгаар цасан болон шороон шуурга шуурч, ихэнх нутгаар хүйтэрнэ. Нэг болон хоёр, гуравдугаар арав хоногуудын эхэн үеүдээр ихэнх нутгаар агаарын температур хүйтрэх төлөвтэй байгаа тул эдгээр үеүдэд цаг агаарын нарийвчилсан мэдээг цаг тухайд авч ашиглахыг зөвлөж байна.